



МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Ёс зүйн дүрэм шинэчлэн батлах тухай

Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.1, Засгийн Газрын 2019 оны 33 дугаар тогтоолын 2-р заалт, Консерваторийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.3.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Консерваторийн ёс зүйн дүрмийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Ёс зүйн зөрчил гомдлыг батлагдсан дүрмийн хүрээнд шударга шийдвэрлэж ажиллахыг Ёс зүйн хорооны дарга, гишүүдэд даалгасугай.
3. Консерваторийн ёс зүйн дүрмийг ажлын байранд чанд сахин, мөрдөж ажиллахыг нийт багш ажилтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2021 оны 05 дугаар сарын 31-ний А/49 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ПҮРЭВХҮ

**МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН БАГШ, АЖИЛТАН,
СУРАЛЦАГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Ёс зүйн дүрмийн хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Консерватори өөрийн эрхэм зорилгод нийцүүлэн сургалт, эрдэм шинжилгээ, нийгэмд үйлчлэх чиг үүргээ хариуцлагатай биелүүлэхийн тулд нийтлэг үнэт зүйлс, ёс суртахууны зарчим, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгоно.

1.2. Дүрмийн зорилго

Консерваторийн багш, ажилтан, суралцагчийн дагаж мөрдөх ёс суртахууны хэм хэмжээ, зарчмыг тогтоон сахиулах, ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх, зөрчил гаргасан этгээдэд сахилгын хариуцлага хүлээлгэхэд энэхүү ёс зүйн дүрмийг баримтална.

1.3. Консерваторийн багш, ажилтан, суралцагчийн эрхэмлэвэл зохих ёс зүйн зарчмууд

1.3.1 Хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, үнэнч шударга, зарчимч байдлыг эрхэмлэн, ёс, дэг журмыг сахин биелүүлэх нь Консерваторийн багш, ажилтан, суралцагч бүрийн эрхэм үүрэг мөн.

1.3.2 Консерваторийн захиргаа нь багш, ажилтны мэргэжлийн үнэ цэнийг үнэлэхийн зэрэгцээ нийгмийн хариуцлагын үүднээс хүн бүрд чанартай, бүтээмжтэй, үр нөлөөтэй ажиллах боломжоор хангахад анхаарч ажиллана.

1.3.3 Багш, ажилтан, суралцагч нь ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэхийн зэрэгцээ аливаа шударга бус, ёс зүйгүй үйлдэлтэй эвлэршгүй байхыг эрмэлзэнэ.

1.4. Дүрмийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

1.4.1 Дүрмийг яс үндэс, арьс өнгө, хүйсийн ялгаа, улс төр, шашин шүтлэгээс үүдэлтэй аливаа маргаантай асуудлыг хэлэлцэхийг хориглоно.

1.4.2 Консерваторийн багш, ажилтан, суралцагч нь "Ёс зүйн дүрэм"-ийг хэлбэрэлтгүй сахин биелүүлж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх үүрэгтэй.

1.4.3 Консерваторийн удирдах ажилтан "Ёс зүйн дүрэм"-ийг зөрчсөн үйлдэл илэрсэн тохиолдолд нэн даруй үр нөлөөтэй арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

1.4.4 Дүрмийг зөв ойлгож, сахин биелүүлэхийн тулд Консерваторийн гишүүн бүрийн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх, санхүүгийн боломжийг бүрдүүлэх үүргийг Консерваторийн захиргаа хүлээнэ.

1.4.5 Аливаа зөрчил, гомдол, маргаан шийдвэрлэх үйл явцын үр нөлөө, өгөөжийг хангах үүднээс Консерватори болон Консерваторийн гишүүн бүр Дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд тохирсон арга хэмжээ авахыг эрмэлзэх бөгөөд үүнд маргаан таслах албан ёсны болон албан бус ажиллагааг ашиглаж болно.

1.4.6 Дүрмийг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцохдоо Консерваторийн хамт олны эвсэг уур амьсгал, хамтын ажиллагааг хамгаалж, Консерваторийн хамт олны гишүүн бүрийн ёс зүйг дээшлүүлэх бодлого баримтална.

1.4.7 Ёс зүйн дүрмийн зөрчлийг шийдвэрлэхдээ оролцогч талуудын эрх, тэгш байдлыг хангаж, хүсэлт тайлбараа гаргах, нөгөө талын байр суурийг сонсох

үүрэг, аль ч талаас хамааралгүй шийдвэр гаргах зэрэг шударга ёсны нийтлэг зарчмыг баримтална.

- 1.4.8 Консерваторийн захиргааны зүгээс хөдөлмөрийн дотоод дүрэм, журам, хамтын ажиллагааны болон хөдөлмөрийн гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад болох байдлаар энэ дүрмийг хэрэглэж болохгүй.
 - 1.4.9 Ёс зүйн дүрмийн хэрэгжилт нь суралцагч оюутныг хүмүүжүүлэх, хариуцлагатай, зөв зан төлөвшилтэй болгон хүмүүжүүлэх гэсэн багшийн мэргэжлийн үүрэгт сөрөг байдлаар нөлөөлж болохгүй.
 - 1.4.10 Энэхүү дүрмийг хамтын гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр аливаа эвсэл холбоод өөрийн гишүүний ашиг сонирхлыг хамгаалах, зөвшөөрөгдсөн эрхээ хэрэгжүүлэхэд саад болох байдлаар хэрэглэж болохгүй.
 - 1.4.11 Энэхүү дүрэм нь харилцаанд оролцогч этгээдийн аливаа хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах эрхийг хөндөх ёсгүй.
 - 1.4.12 Энэхүү дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, бага, дунд, мэргэжлийн боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Консерваторийн дүрэм, хөдөлмөрийн хамтын гэрээнд заасан зохицуулалтад нийцсэн байна.
- 1.5 Дүрмийн үйлчлэх хүрээ
- 1.5.1 Консерваторийн багш, ажилтан бүр энэхүү ёс зүйн дүрэм болон Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтад заасан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
 - 1.5.2 1-12-р ангид хичээл зааж буй багш нар БСШУС-ын 2007 оны 41 тоот тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм"-ийг энэхүү дүрмийн нэгэн адил дагаж мөрдөнө.
 - 1.5.3 Консерваторитой гэрээгээр ажиллаж буй бусад байгууллагын ажилтан гэрээнд заасны дагуу ажил үүрэг гүйцэтгэх явцдаа, суралцагч оюутан суралцах хугацаандаа энэхүү дүрмийг мөрдөнө.
 - 1.5.4 Консерваторийн эзэмшил газарт болон Консерваториас зохион байгуулж буй ажил, үйл ажиллагааны явцад ёс зүйн дүрэм хэрэгжинэ.

1.6 Нэр томьёо

Дүрэмд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

- "Дүрэм" гэж энэхүү Консерваторийн гишүүний ёс зүйн дүрмийг;
- "Консерваторийн гишүүн" гэж Консерваторийн багш, ажилтан, ажилчин, удирдах зөвлөлийн гишүүн, суралцагчийг;
- "Консерваторийн удирдах ажилтан" гэж бүх шатны шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтныг;
- "Консерваторийн ажилтан" гэж Консерваторийн захиргаа, аж ахуй, санхүү, сургалтын алба, эрдэм шинжилгээ, гадаад харилцаа, багшийн хөгжлийн төв, номын сан, үйлчилгээний ажилчныг;
- "Консерваторийн суралцагч" гэж Консерваторийн сурагч, оюутан, магистрант, докторант, мэргэжил дээшлүүлэгчийг;
- "Ашиг сонирхлын зөрчил" гэж Консерваторийн гишүүн аливаа үйл ажиллагаандаа амин хувийн болон эдийн засгийн ашиг олох үүднээс Консерваторид материаллаг, материаллаг бус хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэхийг;

- “Зөрчил” гэж Дүрмийн заалтыг зөрчсөн Консерваторийн гишүүний үйлдэл, эс үйлдэхүйг;
- “Гомдол” гэж зөрчлийн улмаас хохирсон гэж үзэж Консерваторийн гишүүн эсвэл түүний төлөөллөөс эрх бүхий этгээдэд зохих журмаар хандаж, уг хохирлыг арилгуулахаар гаргасан хүсэлтийг;
- “Маргаан” гэж Консерваторийн гишүүний гаргасан гомдлыг Дүрэмд заасан ажиллагаа явуулан зөрчлийн үнэн бодит байдлыг шалгуулахаар зөрчил гаргасан Консерваторийн гишүүн болон энэхүү дүрмээр эрх олгогдсон этгээд шаардсаныг;
- “Маргаан таслах ажиллагаа” гэж Дүрэмд заасан ажиллагаа явуулж, зөрчил гаргасан болон гомдол гаргасан Консерваторийн гишүүдийн хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэхийг тус тус хэлнэ.

ХОЁР. КОНСЕРВАТОРИЙН ГИШҮҮНИЙ ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

2.1. НИЙТЛЭГ ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ.

Консерваторийн гишүүн бүр сургалтын үйл ажиллагаа, боловсролын чанар, стандарт, үйлчилгээ, үр өгөөжийг дээшлүүлж, сургалтын орчныг боловсронгуй болгоход хариуцлагатай, харилцан тэгш хүндэтгэлтэй, аливаа шийдвэр гаргахдаа ухаалаг, асуудалд үндэслэлтэй, үнэнч шударга, зарчимч, хүнлэг байх зарчим баримтална.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.1.1 Үзэл бодол, зан суртахуун, үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина;
- 2.1.2 Шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна;
- 2.1.3 Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэнэ;
- 2.1.4 Ард түмэндээ чин сэтгэлээс үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдэлнэ;
- 2.1.5 Албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байна;
- 2.1.6 Албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байна;
- 2.1.7 Захирах, захирагдах ёсыг сахин биелүүлнэ.
- 2.1.8 Энэ дүрмийн 2.1.1-д заасан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх хэм хэмжээний хүрээнд:
 - 2.1.8.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байгаа соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлах;
 - 2.1.8.2. Хууль зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;
 - 2.1.8.3. Харьяалах дээд шатны албан тушаалтныг хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээллээр хангах;
 - 2.1.8.4. Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх;
 - 2.1.8.5. Төрийн болон байгууллагын, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хамгаалах;

- 2.1.8.6. Бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй байх;
- 2.1.8.7. Удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх.
- 2.1.9. Энэ дүрмийн 2.1.2-т заасан шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:
 - 2.1.9.1. Өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;
 - 2.1.9.2. Өөрийн хөрөнгө, орлогын байдал, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;
 - 2.1.9.3. Төрийн байгууллагын эд хөрөнгө, хөгжмийн зэмсэг, хэрэгсэл, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх, эд хөрөнгө, хөгжмийн зэмсэг, хэрэгслийг хайр гамтай, цэвэр нямбай ашиглах;
 - 2.1.9.4. Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд хууль бусаар давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс бэлэг, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, бусад хангамж эдлэхгүй байх;
 - 2.1.9.5. Хамаарал бүхий этгээдийн ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх.
- 2.1.10. Энэ дүрмийн 2.1.3-т заасан төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх хэм хэмжээний хүрээнд:
 - 2.1.10.1. Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх;
 - 2.1.10.2. Албан тушаалын эрхээ ашиглан бусдыг дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй байх;
 - 2.1.10.3. Жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх;
 - 2.1.10.4. Төрт ёс, түүх, соёлын өв уламжлалаас суралцах, Монголын ард түмний соёл, зан үйлийг хүндэтгэх;
- 2.1.11. Энэ дүрмийн 2.1.4-т заасан ард түмэндээ чин сэтгэлээс үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх хэм хэмжээний хүрээнд:
 - 2.1.11.1. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгчтэй эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;
 - 2.1.11.2. Төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх;

- 2.1.11.3. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэж, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих;
- 2.1.11.4. Төрийн байгууллагаас явуулж байгаа бодлого, хууль ёсны үйл ажиллагааг үл эсэргүүцэх, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх;
- 2.1.12. Энэ дүрмийн 2.1.5-д заасан албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээх хэм хэмжээний хүрээнд:
 - 2.1.12.1. Албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцах;
 - 2.1.12.2. Ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх;
 - 2.1.12.3. Энэ дүрмийн 2.1.6-д заасан албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байх хэм хэмжээний хүрээнд:
 - 2.1.12.4. Төрийн алба хаах хугацаанд улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс аливаа үүрэг хүлээхгүй, нөлөөлөлд автахгүй байх;
- 2.1.13. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;
- 2.1.14. Энэ дүрмийн 2.1.7-д заасан захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх хэм хэмжээний хүрээнд:
 - 2.1.14.1. Удирдлагадаа байгаа албан хаагчдын өмнө нэр хүнд, ажил хэргийн үлгэр жишээг үзүүлэх;
 - 2.1.14.2. Хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх;
 - 2.1.14.3. Хамт олны дунд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх, зөрчлийг зохицуулах;
 - 2.1.14.4. Авлигын орчин үүсэхээс урьдчилан сэргийлэх;
 - 2.1.14.5. Удирдлагадаа байгаа ажилтныг улс төрийн үйл ажиллагаанд татагдан орохоос сэргийлэх;
 - 2.1.14.6. Ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс сэргийлэх, ёс зүйн сургалт зохион байгуулах;
 - 2.1.14.7. Удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх;
 - 2.1.14.8. Албан харилцаанд хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц, нэр төр, алдар хүндийг эрхэмлэх зарчим баримтлах;
 - 2.1.14.9. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;
 - 2.1.14.10. Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх.

2.2. БАГШИЙН ДАГАЖ МӨРДӨХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

- 2.2.1. Багш оюутан, суралцагсдадаа бие даан бүтээлчээр суралцах, өөрийгөө хөгжүүлэх чадвар эзэмшүүлэхэд анхаарч бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.2. Багш оюутан, суралцагсдадаа хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ харилцааны өндөр соёлтой байж тэдний сурах үйл ажиллагааг чиглүүлэгч, удирдагч, зөвлөгч нь байна.
- 2.2.3. Багш оюутан, суралцагчдын сургалт, хүмүүжил, ёс суртахууны төлөвшилд байнга анхаарч ажиллана.
- 2.2.4. Багш хичээлийн стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрийн агуулга, хичээлийн үр дүнг өндөр түвшинд хэрэгжүүлнэ.
- 2.2.5. Багш оюутан, суралцагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг бодит шударга үнэлж, дүгнэнэ.
- 2.2.6. Хамт ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгчдийн нэр төр, эрх ашгийг хүндэтгэн адил тэгш, хүлээцтэй харилцана.
- 2.3. БАГШЛАХ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХОРИГЛОХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ:
- 2.3.1. Суралцагсдын нас, хүйс, үндэс угсаа, хэл яриа, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн байдал зэргээр ялгаварлан гадуурхах;
- 2.3.2. Суралцагчийг хүндэтгэх шалтгаангүйгээр сургалтад болон бусад арга хэмжээнд оруулахгүй байх, хичээлээс хөөж гаргах;
- 2.3.3. Багш өөрөө хүндэтгэх шалтгаангүйгээр хичээлээс хоцрох, хичээл таслах, суралцагчдыг цагаас нь өмнө тараах, хичээлийн цагаар танхимыг орхих, гар утсаар хэт удаан ярих;
- 2.3.4. Хичээлийн болон шалгалтын хуваарийг дур мэдэн өөрчлөх;
- 2.3.5. Суралцагчдад хичээлийн гарын авлага материал, ном, сурах бичгийг худалдан авахыг хүчээр тулгах, хуульд заагаагүй төлбөр, хураамж авах;
- 2.3.6. Шалгалтын дүнг суралцагчийн ур чадварт нийцгүй өндөр тавих, мэдлэг, ур чадварыг нь тухайн үеийн сэтгэл хөдлөлөөр үнэлж дүгнэх, засварлах;
- 2.3.7. Суралцагчдад үзэл бодлоо тулгах, бүдүүлэг үг хэллэгээр загнах, нэр хоч өгөх, айлган сүрдүүлэх зэргээр зүй бус авирлах;
- 2.3.8. Хамт ажиллагсадтай зүй бус харилцаж тэдний нэр хүнд, эрх ашгийг үл хүндлэх;
- 2.3.9. Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааг мушгин гуйвуулсан, худал мэдээ, мэдээлэл тараах;
- 2.3.10. Олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн сувгуудаар байгууллага, хамт олныг болон хэн нэгнийг гутаан доромжилсон үг хэллэг бүхий үйлдэл хийх;

2.3.11 Судалгааны ажлын хүрээнд:

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тогтсон хэм хэмжээг баримтална. Үнэнийг эрэлхийлэх, шинэ мэдлэг бүтээх, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрхэмлэх, шинжлэх ухааны хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах нь Консерваторийн багш, эрдэм шинжилгээний ажилтны судалгааны ажлын хүрээнд баримтлах тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- Эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх;
- Бусад багш, судлаачийн эрдмийн эрх чөлөөг хүндэтгэх;
- Бусад судлаач, эрдэмтдийг хувь хүнийх нь хувьд хүндэтгэхийн зэрэгцээ бүтээлд нь рациональ шүүмжлэлтэй хандах;
- Эрдэм шинжилгээний ажлыг багаар буюу хамтарч гүйцэтгэх тохиолдолд багийн гишүүдийн үүрэг оролцоо, ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан төсвийг шударга хуваарилж, зарцуулах;

- e) Консерваторийн нэрээр аливаа төсөлт ажил удирдах, оролцох тохиолдолд энэ талаар тодорхой мэдээлж тайлагнах;
- f) Судалгаа, эрдэм шинжилгээний ажилд залуу багш, судлаач, суралцагчдын оролцоог дэмжих;
- g) Өөр үзэл бодол, байр суурь, арга хандлагыг хүлцэх.

Хориглосон хэм хэмжээ

- a) Бусдын бүтээл, санааг хулгайлах, ишлэлгүй ашиглах, хуулбарлах, зохиогчийн зөвшөөрөлгүй ашиглах;
- b) Бусдын бүтээлийг өөрийн болгож илэрхийлэх;
- c) Хамтын бүтээлийг дангаар хийсэн мэт илэрхийлэх;
- d) Судалгаанд хамтарч оролцсон эрдэм шинжилгээний ажилтан, суралцагчид, туслах ажилтны эрх ашиг, нэр төрийг сэвтээх, оролцооны хувь нэмрийг шударга бус үнэлэх;
- e) Судалгааны үр дүнг дөвийлгөх, үнэн байдлыг гуйвуулах, зохиомлоор тайлагнах;
- f) Сургуулийн болон тухайн судлаачийн нэрийг зөвшөөрөлгүй ашиглах;
- g) Сургалт, судалгааны ажлын хүрээнд намчирхах, улс төржих, үзэл суртлын байр сууринаас хандах.

2.3.12 Нийгэмд үйлчлэх хүрээнд:

Ардчиллын суурь зарчмуудыг дээдэлж, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлан, нийгмийн сайн сайхны төлөө зүтгэнэ. Улс эх орноо хөгжүүлэх, төрийн (улс төр, эдийн засаг, нийгмийн) бодлогыг үндэс суурьтай зориулах, нийгэмд манлайлах, үлгэр дуурайл үзүүлэх, багшийн нэр хүндийг өндөрт өргөх нь Консерваторийн багшийн нийгэмд үйлчлэх хүрээнд баримтлах тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- a) Консерваторийн багшийн нийгмийн хариуцлагыг ухамсарлах, тэдгээрийг бүрэн хүлээн зөвшөөрч, дэмжих;
- b) Улс, нийгмийн өмнө тулгарч буй асуудалд алсын хараатай, бүтээлч, шүүмжлэлт байр сууринаас хандаж, мэргэжлийн үүднээс ажил хэрэгч санал дэвшүүлэх;
- c) Мэргэжил, мэдлэг, судалгааныхаа үр дүнг нийтэд зарлах, түгээх, нэвтрүүлэхдээ хүнлэг байж, нийтийн эрх ашигт нийцүүлэх;
- d) Нийгэмд хүргэж буй мэдээлэл нь шударга, бодитой, үндэслэлтэй байх;
- e) Мэргэжлийн шүүмж өгөх, шүүмж хүлээн авах.

2.4. ХАРИЛЦААНЫ ЁС СУРТАХУУНЫ ХЭМ ХЭМЖЭЭ

Хувь хүний эрхэм оршихуйг дээдлэн, байгууллага, хувь хүний харилцаанд шударга, зарчимч, иргэний өндөр соёлтой, ёс жудагтай, үнэнч, хүнлэг байж, багшийн нэр төрийг эрхэмлэн дээдэлнэ.

2.4.1. Суралцагчидтай харилцах

Суралцагсдын язгуур эрх ашгийг дээдэлж, танин мэдэх чөлөөт эрмэлзлийг дэмжин хөгжүүлж, харилцан хүндэтгэлтэй, тэгш, шударга, бодитой хандах, харилцан итгэл хүлээсэн байх нь Консерваторийн багш, суралцагсдын хоорондын харилцааны тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- a) Суралцагч санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх уур амьсгалыг бүрдүүлэх;
- b) Суралцагчийн эрдэм мэдлэгт хандах идэвх санаачилгыг өрнүүлж, оюуны эрэл хайгуулд хамтдаа зүтгэгч хэмээн хүндэтгэж харьцах;
- c) Суралцагчийг харилцааны өндөр соёлтой иргэн болж төлөвшихөд нь туслах, биеэр үлгэрлэх;

Хориглосон хэм хэмжээ

- a) Хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн суралцагчийн хөдөлмөрийг ашиглах;
- b) Мэргэжлийн эсвэл хуулийн зайлшгүй шаардлага гарснаас бусад тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан суралцагчийн талаарх мэдээллийг бусдад задруулах;
- c) Суралцагчийг хүйсээр болон бусад байдлаар ялгаварласан, ичээн зовоож, гутаан доромжилсон үг хэлэх, үйлдэл хийх;
- d) Суралцагчид бэлгийн дарамт үзүүлэх, бэлгийн харьцаанд орох;
- e) Багшийн байр суурийн давуу байдлыг ашиглан суралцагчид аливаа дарамт, шахалт үзүүлэх;

2.4.2. Хамт олонтой харилцах

Харилцан тэгш, хүндэтгэлтэй, итгэл хүлээсэн, хүнлэг байх, харилцааны өндөр соёлтой, аливаа санал өгөх, шийдвэр гаргахдаа ухаалаг, үндэслэлтэй байж зүйд нийцүүлэх, асуудалд ил тод, нээлттэй, шударга, бодитой хандах нь Консерваторийн багш, хамт олны харилцааны тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- a) Бусадтай ялгаварлалгүй, хүндэтгэлтэй харилцах;
- b) Бусдын ажил, бүтээлд мэргэжлийн үүднээс шударга, бодит үнэлгээ, шүүмж өгөх;
- c) Багаар ажиллахдаа цаг барьж, цахим хуудас, захиагаа тогтмол шалгах;
- d) Багаар ажиллахдаа урьд өмнө үүссэн үзэл бодлын ялгаа, зөрүүтэй байдал, одоогийн ажилд үл хамаарах маргаан, санал нийлээгүй үр дүнгээс ангид байх;

Хориглосон хэм хэмжээ

- a) Санал өгөх, шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчил гаргах;
- b) Байр суурийн давуу байдлаа ашиглах;
- c) Бусдын ажил, бүтээлийг дүгнэхдээ мэргэжлийн бус шалгуураар хандах, мэргэжлийн ур чадварыг нь буруу илэрхийлэх, дутуу үнэлэх;
- d) Мэргэжил, мэргэшлийн мэдлэг чадвартай холбоотой материалаа нуун дарагдуулах, худал мэдүүлэг хийх;
- e) Ажил мэргэжилд өрсөлдөж байгаа хүний мэдлэг, чадварын талаар санаатай худал мэдүүлэг гаргах;
- f) Багшлах эрхгүй хүний багшлах хууль бус үйлдэлд нь туслах;

2.5. УДИРДАХ АЖИЛТАН БОЛОН БУСАД АЖИЛТНЫ ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

2.5.1. Ажил үүрэгтэй холбоотой хэм хэмжээ

Боловсролын чанар, стандарт, үйлчилгээ, үр өгөөжийг дээшлүүлж, сургалтын орчныг боловсронгуй болгох үйл хэрэгт хариуцлагатай, чин үнэнч хандаж, бүтээлч хувь нэмрээ оруулах нь Консерваторийн ажилтан, ажилчдын эрхэм үүрэг, хариуцлага мөн.

2.5.2. Нийтлэг хэм хэмжээ

Үүрэг болгосон хэм хэмжээ

- a) Үүрэгт ажлаа хариуцлагатай, идэвх санаачилгатай гүйцэтгэх;
- b) Ажлын цаг баримталж, үр өгөөжтэй, бүтээлч ашиглах;
- c) Мэдээллийг нээлттэй, ил тод, тогтмол байлгаж, Консерваторийн гишүүнд шаардлагатай, хүссэн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх;
- d) Консерваторийн гишүүн болон тэдний төлөөллөөс тавьж буй шүүмжлэл, шаардлага, өргөдөл, гомдлыг бодит үндэслэлтэй, тэгш, шударга шийдвэрлэх.

Хориглосон хэм хэмжээ

- a) Хувийн ашиг сонирхлын үүднээс сургуулийн аж ахуйн үйл ажиллагаанд ямарваа нэг санал тавих, мэдээлэл, сурталчилгаа хийх, зөвшөөрөл олгох, шийдвэр гаргах;
- b) Үүрэгт ажлаа хувийн ашиг сонирхолтой хольж хутгах, эсвэл бусдад тийм хардлага төрүүлэх нөхцөл байдал үүсгэх;
- c) Боловсон хүчнийг ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, ажилд томилох, шагнал урамшуулалд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэхэд ашиг сонирхлын зөрчил гаргах, ил тод байдлыг үл хангах;
- d) Эрх мэдлээ урвуулан ашиглаж ойр дотнын харьцаатай хүмүүст давуу боломж олгох, дэмжлэг үзүүлэх;
- e) Мэргэжлийн эсвэл шинжээчийн байр сууринаас олон нийтэд хандах тохиолдолд сургуулийн ажилтны нэрийг ашиглаж болох боловч хувийн бодол, үнэлэлт, дүгнэлт гэдгээ үл онцлох;
- f) Урьдчилан зохих зөвшөөрөл авалгүйгээр сургуулийн нэр ашиглан бараа бүтээгдэхүүний реклам, сурталчилгаа хийх;
- g) Ажил мэргэжилд өрсөлдөж байгаа хүний мэдлэг, чадварын талаар санаатай худал мэдүүлэг гаргах.

2.5.3. Тусгай хэм хэмжээ

Удирдах ажилтан

- a) Боловсролын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд идэвх санаачилгатай, бүтээлч, хариуцлагатай оролцох;
- b) Сургууль, мэргэжлийн сургууль, нэгжийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, бодлого боловсруулах чадвартай байж, түүний хэрэгжилт, явц, үр дүнд анхаарч ажиллах;
- c) Удирдах арга барил, хууль эрх зүй, менежментийн мэдлэг, чадвараа байнга дээшлүүлж, сургуулийн хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмэр оруулах;
- d) Сургалт, эрдэм шинжилгээний түвшнийг орчин үеийн хөгжлийн шаардлага, шинжлэх ухаанч академик чиг хандлагатай нийцүүлэн шинэчилж байх;
- e) Сургуулийн багш, ажилтан, ажилчин, суралцагчдын идэвх санаачилгыг өрнүүлж, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх;
- f) Сургуультай холбоотой мэдээллийг хамт олонд ил тод нээлттэй байлгах;
- g) Аливаа шийдвэрийг сургууль, хамт олны эрх ашгийн үүднээс ухаалаг, зүй зохистой, үндэслэлтэй гаргах, шийдвэрийн үр дүнд хяналт тавих;
- h) Аливаа тендер, сонгон шалгаруулалт, худалдах, худалдан авах, боловсон хүчнийг сонгох, дэвшүүлэх зэрэгт өөрийн хамаатан садан, хувийн ойр дотно харилцаатай найз нөхдийг дэмжих, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;
- i) Хувийн болон хамаатан садан, ойр дотно харилцаатай хүмүүст бизнесийн шууд ба шууд бус ашиг олгох боломжийг бүрдүүлэхгүй байх;
- j) Сургуулийн эд хөрөнгийг хувийн ашиг сонирхлоор бусдад ашиглуулахгүй байх.

Ажилтан, ажилчин

- a) Ажил, үүрэгтэй холбоотой мэдээлэл олж авах боломжийг нээлтэй байлгах;
- b) Сургуулийн удирдлага, багш, ажилтан, ажилчин, суралцагчдад холбогдох үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх;
- c) Сургуулийн байр, хөгжмийн зэмсэг, техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, оюуны бүтээлийг зүй зохистой, гамтай ашиглах;
- d) Албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх.

2.6. ХАРИЛЦААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ

Харилцан тэгш, хүндэтгэлтэй байх, харилцааны өндөр соёлтой, аливаа санал өгөх, шийдвэр гаргахдаа ухаалаг, зүйд нийцүүлэх, асуудалд үндэслэлтэй, ил тод,

нээлттэй шударга, бодитой хандах, хүнлэг байх нь Консерваторийн хамт олны харилцааны тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- a) Ямар албан тушаалд ажиллаж байгаагаас үл хамаарч бие биетэйгээ шударга, хүндэтгэлтэй харилцах;
- b) Багаар ажиллахдаа цаг барьж, цахим хуудас, захиагаа тогтмол шалгах;
- c) Багаар ажиллахдаа урьд өмнө үүссэн үзэл бодлын ялгаа, зөрүүтэй байдал, одоогийн ажилд үл хамаарах маргаан, санал нийлээгүй үр дүнгээс ангид байх;
- d) Багш, ажилтан, ажилчид, суралцагчдад тэгш, хүртээмжтэй, эелдэг, соёлч боловсон, хөнгөн шуурхай үйлчлэх.

Хориглосон хэм хэмжээ

- a) Хувийн ашиг сонирхолд нийцүүлэн доод тушаалын хүмүүсийн болон суралцагчийн хөдөлмөрийг завших;
- b) Байр суурийн давуу байдлаа ашиглах;
- c) Шударга бусаар бусдын нэр төр, байр суурийг гутаан албан тушаал, мэргэжлийн салбарт ахиж дэвших боломжийг хаах, саад учруулах.

2.7. СУРАЛЦАГЧИЙН ДАГАЖ МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

2.7.1. Суралцах үйл ажиллагаанд дагаж мөрдөх хэм хэмжээ

Консерваторийн суралцагч бүр эрдэм мэдлэг эзэмших зорилгоо эрхэм болгож, ямагт өөрийгөө хөгжүүлж, сурлагадаа ахиц дэвшил гаргаж байх нь суралцагчийн эрх ашигт бүрэн нийцэх төдийгүй улс орны хөгжил цэцэглэлтийн үндэс мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- a) Суралцагч нь багш шавийн барилдлагыг хүндэтгэх;
- b) Консерваторийн суралцагчдын дүрэм, журам, заавар, зөвлөмжтэй танилцаж, дагаж мөрдөх;
- c) Хичээлийн хөтөлбөр, хуваарь, цаг баримтлах;
- d) Хичээлийн цагийг зүй зохистой, үр бүтээлтэй ашиглах;
- e) Даалгавар, ангийн ажил, бие даалтыг цаг хугацаанд нь гүйцэтгэх, хүлээлгэн өгөх;
- f) Сургуулийн өмч хөрөнгө, хөгжмийн зэмсэг, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, гарын авлага, анги танхимын эд хогшил, ширээ сандлыг ариг гамтай эдэлж ашиглах.

Хориглосон хэм хэмжээ

- a) Хичээл таслах, хичээлээс хоцрох, хичээл дундуур гарч явах;
- b) Хичээлийн цагаар бусдын сурах үйл ажиллагаанд саад учруулах, бусдын тавьсан шаардлагыг үл ойшоож хичээлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах;
- c) Шалгалтын ажлыг гүйцэтгэх явцад бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл авах, шалгалтад зөвшөөрөгдөөгүй материал авч орох, ашиглах, гар утас, цахим хэрэгсэл хэрэглэх;
- d) Бусдын өмнөөс шалгалт өгөх, бусдыг өөрийнхөө өмнөөс шалгалтад оруулах;
- e) Бие даан гүйцэтгэхээр заасан ажил, дадлага, судалгааны ажил, хичээлийн бие даалт гүйцэтгэхдээ бусдаар хийлгэх, бусдын хийсэн зүйлийг хуулбарлах;
- f) Судалгааны ажил, судалгааны үр дүн бусад даалгаврыг хуурамчаар, зохиомлоор үйлдэх;
- g) Хичээлийн даалгавар, бие даалтын ажил гүйцэтгэхдээ бусдын хийсэн ажил, дэвшүүлсэн санааг өөрийн болгож хууран мэхлэх. Үүнд, дараах тохиолдолд хууран мэхэлсэн гэж үзнэ: Бусдын бүтээлийг хуулсан; Өөр үгээр илэрхийлсэн боловч утга санаа нь хэвээр хадгалагдсан; Бусдын санааг зөвшөөрөлгүй, зүй бусаар ашигласан;

- h) Нэг хичээлийн даалгаврын гүйцэтгэлд шалгуулж үнэлгээ авсан ажлыг өөр хичээлийн даалгаварт шалгуулж, давхар үнэлүүлэх;
- i) Багшийн өгсөн дүн, оноог засаж үнэлгээг өөрчлөх;
- j) Дүнгийн хуудас, сурлагын дэвтэр, оюутны үнэмлэх, биеийн байцаалт, хөнгөлөлтийн хуудас, тодорхойлолт зэрэг албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, засвар оруулах, өөрчлөх, зүй бусаар бусдад дамжуулах, ашиглуулах;
- k) Суралцах явцад бусадтай шударга бусаар өрсөлдөх. Үүнд, дараах тохиолдолд шударга бусаар өрсөлдсөн гэж үзнэ: Өөртөө болон хэн нэгэнд шударга бусаар давуу байдал бий болгох; Сургалтын материалыг бусдаас хулгайлах, нуун дарагдуулах, өөрчлөх; Дүгнэх аргачлалыг будилуулах;
- l) Хичээлийн цагаар хичээлд холбогдолгүй зүйл хийх, утсаар ярих, захидал бичих, тоглох, дуу хөгжим сонсох зэргээр цахим хэрэгслийг хичээлийн бус зориулалтаар ашиглах;
- m) Сургалтын хэрэглэгдэхүүн, номын сангийн сурах бичиг, гарын авлагыг зүй зохисгүй ашиглах, гэмтээх, устгах, дахин ашиглах боломжгүй болгох;

2.8. СУРАЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БУСАД ХҮРЭЭНД ДАГАЖ МӨРДӨХ

ХЭМ ХЭМЖЭЭ:

Консерваторийн суралцагч бүр өөрийн үнэ цэнэ, эрхэм оршихуйг хамгаалахын зэрэгцээ орчин тойрныхоо хүмүүс, багш, ажилтан, хамт суралцагчийн эрхэм оршихуйг хүлээн зөвшөөрч, тэдэнд хүндэтгэлтэй хандаж, эрх ашигт нь хохирол учруулахаас зайлсхийж, нийтийн дунд биеэ зөв боловсон авч явах нь эрдэм мэдлэг олж авах үндсэн зорилгод нь бүрэн нийцнэ.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- a) Багш, ажилтан, ажилчид, бусад суралцагчидтай харилцааны өндөр соёлтой, хүндэтгэлтэй харилцах;
- b) Сургуулийн эд хөрөнгө, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмжийг ариг гамтай, зориулалтын дагуу ашиглаж, зөв боловсон үйлчлүүлэх.

Хориглосон хэм хэмжээ

- a) Анги, курс, хот хөдөө, нас, физиологийн зэрэг ялгаа үүсгэн бусдыг айлган сүрдүүлэх, эрхшээлдээ оруулах, зодож гэмтээх, элдэв татаас татах, дарамтлах, нэр төрийг нь гутаах;
- b) Хуурамч дуудлага өгөх, бусдыг хилсээр буруутгах, мэдээллийг гуйвуулах, нуун дарагдуулах, худал мэдээлэх, хутган үймүүлэх, бусдыг гүтгэх, худал мэдүүлэх зэрэг ноцтой үйлдэл гаргах;
- c) Сургуулийн эрх бүхий албан тушаалтан, багш, ажилтан, ажилчид, суралцагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, биеийн байцаалтаа гаргаж өгөхгүй байх, сахилгын арга хэмжээг үл биелүүлэх;
- d) Сургуулийн анги, танхим, албан тасалгаа, дотуур байранд зөвшөөрөлгүй нэвтрэх, дотор нь байрлах;
- e) Сургуулийн орчинд хэт чанга дуу авиа гаргах, орилох, исгэрэх, чанга инээлдэх
- f) Сургуулийн орчинд элдэв хог, шүлс, нус цэр, бохь, тамхины иш хаях, цонх, тагнаас элдэв юм шидэх, тамхи татах;
- g) Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалтын ажилчдыг үл ойшоох, хөдөлмөрийг нь үл хүндлэх;

- h) Сургуулийн дүрэм, журамд зааснаас бусад тохиолдолд халуун, хүйтэн болон галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис зэрэг аюултай зэвсэг, хэрэгсэл ашиглах, хадгалах, эзэмшилдээ байлгах;
- i) Хуулиар хориглосон арга, хэлбэрээр мансууруулах бодис хэрэглэх, түгээх, борлуулах, эзэмшилдээ байлгах;
- j) Сургуулийн газар хөзөр, компьютерын тоглоом зэргээр тоглох, мөрийтэй тоглох.

ГУРАВ. Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам

3.1. Нийтлэг үндэслэл

3.1.1. Ёс зүйн зөвлөл нь багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

3.1.2. Ёс зүйн зөвлөл нь "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм", "Монгол улсын Консерваторийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм", холбогдох хууль тогтоомж болон энэ журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

3.1.3. Ёс зүйн зөвлөл нь үйл ажиллагаандаа тэгш хандах, шударга ёсыг баримтлах, нууцыг хадгалах, хараат бус байх зарчмыг баримтална.

3.2. Ёс зүйн зөвлөл

3.2.1. Ёс зүйн зөвлөл 7 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн гишүүнээр Консерваторид 8-аас доошгүй жил ажилласан, хамт олондоо нэр хүндтэй, ёс зүйн аливаа зөрчилд холбогдож байгаагүй багш, ажилтан албан хаагчдын саналыг үндэслэн Монгол улсын Консерваторийн захирал гурван жилийн хугацаагаар томилно.

3.2.2. Ёс зүйн зөвлөлийн гишүүд даргаа сонгож тогтоол гаргана. Зөвлөлийн хуралдааныг зөвлөлийн дарга, эзгүйд нь томилсон гишүүн даргална, хуралдааны дэгээ өөрсдөө тогтооно.

3.2.3. Ёс зүйн зөвлөлийн гишүүн нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг шалгах, зөвлөлийн хуралдаанд оролцож саналаа илэрхийлэх, зөвлөлийн даргын томилсноор хуралдааныг даргалах эрхтэй, хурлаас гарах шийдвэрт хариуцлагатай оролцох үүрэгтэй.

3.2.4. Ёс зүйн зөвлөлийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна зөвлөлийн хурлыг товлон зарлах, бэлтгэлийг хангуулах, хурлыг удирдах, гомдол, хүсэлтийг хүлээн авах, өөрийн эзгүйд зөвлөлийн хурлыг удирдах гишүүнийг томилох эрхийг эдэлнэ.

3.2.5. Ёс зүйн зөвлөлийн нарийн бичгийн даргаар Консерваторийн хүний нөөцийн асуудал эрхэлсэн ажилтан ажиллана. Нарийн бичгийн дарга нь зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрт гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулах, баримт бичгийг эмхэлж архивын нэгж болгох, зохих байгууллага, иргэнд Ёс зүйн зөвлөлийн шийдвэрийг хүргүүлэх, танилцуулах ажиллагааг тус тус хариуцан ажиллана.

3.2.6. Гомдол гаргагч нь "Ёс зүйн зөвлөл"-д өргөдлөө ирүүлэхдээ болсон үйл явдлын талаар баримт, нотолгоотойгоор тодорхой бичиж нэр, хаяг, гарын үсгийг зурсан байна.

3.2.7. Багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн талаарх иргэдийн санал, гомдол, олон нийтийн сүлжээнд цацагдсан хүний нэр төрд халдсан худал, хуурмаг мэдээ, мэдээллийг байгууллагын дотоод хяналт хариуцсан албан тушаалтан хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дараах журмын дагуу шалгалт явуулж шийдвэрлэнэ.

Үүнд:

1. Гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагч болон гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж тэдгээрийн тайлбар, саналыг сонсож тэмдэглэл хөтлөх,

2. Шаардлагатай гэж үзвэл бусад байгууллагаас баримт бичиг, тайлбар, лавлагааны материал гаргуулж авах,

3. Харьяалах нэгжийн удирдлага, албан хаагчидтай уулзаж тодруулга хийх, шаардлагатай баримт, материал цуглуулж дүгнэлт гаргах.

3.2.8. Шалгалт явуулах нэмэлт хугацаа шаардагдах тохиолдолд Консерваторийн захирал тодорхой хугацаагаар сунгаж болно.

3.2.9. "Ёс зүйн зөвлөл"-ийн нарийн бичгийн дарга хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хүлээн авч, "Ёс зүйн зөвлөл"-ийн даргад танилцуулан 14 хоногт багтаан хуралдааны товыг тогтоон, хуралдаанд оролцогчдод мэдэгдэл хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2.10. "Ёс зүйн зөвлөл"-ийн нарийн бичгийн дарга өргөдөл, гомдолтой холбоо бүхий баримт, материалыг хувиран "Ёс зүйн зөвлөл"-ийн гишүүдэд хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байна.

3.2.11. "Ёс зүйн зөвлөл"-ийн хуралдаанд өргөдөл, гомдлын дагуу баримт, материалыг шалгасан албан тушаалтан болон ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчийг оролцуулж асуудлыг шийдвэрлэнэ.

3.2.12. "Ёс зүйн зөвлөл"-ийн хуралдаанд зөрчилд холбогдсон албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол хуралдааныг үргэлжлүүлэх, хойшлуулах эсэхийг хуралдаанд оролцож буй гишүүд хэлэлцэн шийдвэрлэж болно.

3.2.13. "Ёс зүйн зөвлөл"-ийн хуралдаан талуудын тайлбарыг сонсох, нотлох баримт гаргуулах, асуулт асуух, хүлээлгэх хариуцлагын талаар шийдвэр гаргах, хурал хаах зэрэг агуулгатай байна. Хуралдааны явцыг соронзон бичлэгээр болон тэмдэглэл хөтлөн баримтжуулж болно.

3.2.14. "Ёс зүйн зөвлөл"-ийн хуралдаан даргалагч хуралдааны дэгийг сахиулах, дэг журамтай байлгах, шударга ёсыг сахиулах үүрэгтэй. Шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар гаргана.

3.2.15. Талууд тодорхой хүмүүсийг хуралдааны танхимд байлцуулах тухай бичгээр хүсэлт гаргаагүй бол хуралдаан хаалттай явагдах ба хуралдааны тэмдэглэл нууцад хамаарна.

3.2.16. "Ёс зүйн зөвлөл" нь ёс зүйн зөрчил гаргасан багш, ажилтанд зохих хууль дүрмийн холбогдох заалтын дагуу хариуцлага тооцохдоо гаргасан зөрчлийн хор уршиг, сургуулийн хамт олны болон өсвөр үеийнхний сэтгэл зүй, хүмүүжил, сургалтын үйл ажиллагаанд нөлөөлж буй сөрөг үр дагавар зэргийг харгалзан хүлээлгэх шийтгэлийн талаарх саналыг гаргана.

3.2.17. "Ёс зүйн зөвлөл"-ийн хуралдааны шийдвэр эцсийнх байна.

3.2.18. "Ёс зүйн зөвлөл"-ийн хуралдаанаас өмнө талууд эвлэрч болно. Талууд зөвхөн сайн дурын үндсэн дээр эвлэрнэ. Нэгэнт эвлэрсэн бол гомдол, маргааныг эцэслэн шийдвэрлэгдсэнд тооцно.

3.2.19. "Ёс зүйн зөвлөл" нь өргөдөл, гомдлын дагуу баримт, материалыг шалгасан тухай танилцуулгыг зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын ирцтэй хуралдан хэлэлцэж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Монгол улсын Консерваторийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм"-д заасан дараах хариуцлагыг хүлээлгэх тогтоол гаргана. Ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй ёс зүйн зөрчилд тооцогдох бөгөөд Ёс зүйн зөрчилд

1. Уучлал гуйхыг үүрэг болгох,

2. Сануулах

гэсэн хариуцлага хүлээлгэнэ. Мөн Ёс зүйн зөрчил гаргасан үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзан сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөх нь ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.

3.2.20. "Ёс зүйн зөвлөл"-ийн хуралдааны шийдвэрт албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан болох нь баримтаар тогтоогдсон тухай үндэслэл тусгагдсан байх ба шийдвэрт хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурсан байна.

3.2.21. "Ёс зүйн зөвлөл" тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл өргөдөл, гомдол гаргасан иргэн, байгууллагад албан ёсоор бичгээр хариу өгнө.

3.3. Ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, мэдээлэх

3.3.1. "Ёс зүйн зөвлөл"-ийн хурлын тогтоолыг зөрчил гаргасан албан хаагчид танилцуулна.

3.3.2. "Ёс зүйн зөвлөл" тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл өргөдөл, гомдол гаргасан иргэн, байгууллагад албан ёсоор бичгээр хариу өгнө.

3.3.3. "Ёс зүйн зөвлөл" нь энэ дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг тухай бүр боловсруулан шийдвэрлүүлж болно.

3.4. Суралцагчид хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох албан тушаалтан захирлын зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ.

Зөрчил гаргасан суралцагчид хүлээлгэх хариуцлага

- a) Хичээл болон судалгааны ажилд оролцохоос бусад үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар хориг тавих;
- b) Сургуулиас түр чөлөөлөх;
- c) Сургуулиас хасах.

3.5. ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭХ

Шийдвэр биелүүлэх нийтлэг журам

- a) "Ёс зүйн зөвлөл"-ийн маргаан таслах хуралдааны шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилна.
- b) "Ёс зүйн зөвлөл"-ийн маргаан таслах хуралдааны шийдвэрийг холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.
- c) Хариуцагч болон холбогдох эрх бүхий албан тушаалтан "Ёс зүйн зөвлөл"-ийн маргаан таслах хуралдааны шийдвэрийг 10 өдрийн дотор биелүүлэх үүрэгтэй.
- d) Холбогдох албан тушаалтан "Ёс зүйн зөвлөл"-ийн маргаан таслах хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлээгүй бол талууд түүнд хариуцлага тооцуулахаар дээд шатны албан тушаалтанд хандах эрхтэй.

Суралцагч шийдвэр биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ

- a) Суралцагч хурлын шийдвэрийг дурдсан хугацаанд биелүүлээгүй бол тэнхимийн эрхлэгч, сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга тухайн суралцагчаас шалтгааныг тодруулах ярилцлага хийнэ. Ярилцлагад суралцагч хүсвэл өөрийн төлөөлөгчийг байлцуулж болно.
- b) Ярилцлагын дараа шаардлагатай гэж үзвэл тэнхимийн эрхлэгч, сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга Консерваторийн захирлын зөвлөлд дараах саналыг тавьж болно. Үүнд:
 - Хориг тавих арга хэмжээ авсан бол хугацааг сунгах;
 - Шийдвэрийг биелүүлэхээс 2-оос дээш удаа татгалзах тохиолдолд сургуулиас түр чөлөөлөх;

Шийдвэр биелүүлэх хүртэл суралцагчийн суралцах хугацааг хойшлуулна.